*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ МЯГМАРЖАВ ОВОГТОЙ ОРОЛЗОДЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | | | Гүйцэтгэлийн түвшин | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | | 6 | 7 |
| **Зорилт 1. “Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулна.”** | | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1<br>Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагад тавигдах шаардлагыг тодорхойлж, жагсаалтыг шинэчлэн боловсруулна. | Засгийн газрын тогтоолын төслийн тоо | 0 | - | 1 | ЦХИХХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/105 дугаар тушаалаар Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн ажиллаж, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах, жагсаалтыг шинэчлэхэд оролцогч талуудын саналыг тусгахаар 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр “Онц чухал мэдээллийн дэд бүтцийн кибер аюулгүй байдал” сэдэвт арга хэмжээг зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд нийт 83 байгууллагын 115 албан хаагчид оролцож, 57.5 хувь нь онц чухал мэдээллийн дэд бүтцийг байгууллагын нэрээр бус салбар, үйл ажиллагааны чиглэлээр нь тодорхойлохыг санал болгосон. Ажлын хэсгээс кибер аюулгүй байдлын тухай хуульд нийцүүлэн онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагыг | 2025.07-2025.12 сар | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тодорхойлох шалгуур үзүүлэлт, аргачлалыг боловсруулж байна. | | |
| 2. | Арга хэмжээ 1.2.<br>Үндэсний хэмжээнд кибер аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагын тогтолцооны суурь судалгаа хийх, аюулгүй байдлыг шалгах зааварчилгаа боловсруулна. | Судалгааны тоо<br>Зааварчилгааны тоо | 0<br>0 | - | 1<br>1 | Кибер аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагын тогтолцооны суурь судалгаа хийх санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр "Кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх төсөл"-ийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулсан.<br>Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх системийн хөгжүүлэлтийг И-Монгол академи УТҮГ-аас хийж байна. | 2025.09-2025.12 сар | Хэрэгжүүлэх хугацаа болоогүй. |
| **Зорилт 2. "Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх бүтцийн үйл ажиллагааг сайжруулна."** | | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1.<br>Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Нийтийн төвийн төлөвшлийг үнэлэх арга хэмжээг зохион байгуулна | Төслийн тоо | 0 | - | 1 | Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Нийтийн төв УТҮГ-ын төлөвшлийг үнэлэх судалгааг Олон Улсын Цахилгаан холбооны байгууллагатай хамтран 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулахаар тохиролцож, бэлтгэл ажлыг хангаж байна. | 2025.07-2025.12 сар | Хэрэгжүүлэх хугацаа болоогүй. |
| **Зорилт 3. "Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чадавхыг бий болгох, энэ чиглэлийн үйл ажиллагаатай төвүүдийн хамтын ажиллагааг уялдуулан зохицуулна."** | | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 3.1.**<br>Ази номхон далайн бүс нутгийн кибер дадлага, сургуулилт 2025" арга хэмжээг зохион байгуулна. | Арга хэмжээний тоо | 0 | - | 1 | "Ази номхон далайн бүсийн кибер сургуулилт 2025" арга хэмжээг 2025 оны 09 сарын 02-06-ны өдрүүдэд зохион байгуулахаар Олон Улсын Цахилгаан холбооны байгууллагатай тохиролцсон. Хамтын ажиллагааны гэрээний төслийг Монгол хэлнээ орчуулж, Байгууллага хоорондын гэрээ байгуулах журмын 4.1-д заасны дагуу Гадаад харилцааны яамаар хянуулж, гэрээ байгуулах зөвшөөрлийг авсан. Арга хэмжээг зохион байгуулах ажлын даалгаврыг боловсруулж батлуулсан. ЦХИХХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/127 дугаар | 2025.01-2025.12 сар | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тушаалаар арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн хурлаар бэлтгэл ажлын төлөвлөөг боловсруулсан. Мөн ОУЦХБ-тай хамтарсан төлөвлөгөөг боловсруулж, 14 хоног тутам цахимаар хуралдаж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | | |
| | **Арга хэмжээ 3.2** Монгол Улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн түвшинг үнэлэх судалгааны үр дүнг танилцуулж, зөвлөмж гаргана. | Зөвлөмжийн тоо | 0 | 1 | - | Монгол Улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн түвшинг үнэлэх судалгааг Оксфордын их сургуулийн Кибер аюулгүй байдлын чадавхын үнэлгээний төвтэй хамтран 2024 оны 08 дугаар сараас 2025 оны 02 дугаар сарын хооронд зохион байгуулсан. Судалгааны багаас ирүүлсэн тайлангийн төсөлд холбогдох байгууллагуудаас санал авахаар 2025 оны 01 сарын 08-09-ний өдрүүдэд хэлэлцүүлэг зохион байгуулж, ирүүлсэн саналыг нэгтгэн судалгааны багт хүргүүлсэн. Кибер аюулгүй байдлын өнөөгийн түвшнийг үнэлэх судалгааны товч үр дүнг 2025 оны 02 сарын 19-ний өдөр олон нийтэд танилцуулсан. Мөн судалгааны тайлангийн Монгол хэл дээрх орчуулгын хувилбарыг гаргаж, Тагнуулын ерөнхий газарт 2025 оны 02/956 тоот албан бичгээр хүргүүлэн хянуулсан. Улмаар Монгол Улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн түвшин, дараагийн түвшинд хүргэхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд ил тод хүргэсэн. | 2025.01-2025.06 сар | 100% |
| **Зорилт 4. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах”** | | | | | | | | |
| | **Арга хэмжээ 4.1.** Хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хүрээнд | ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоо, | | ТЖАХ-ийн гүйцэтгэлийн биелэлт | | Төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 2025.01 сар | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журмын дагуу боловсруулж батлуулах, тайлагнана. | ТЖАХ-ийн гүйцэтгэлийн биелэлтийн тоо | | ийн тоо - 1 | | | | |
| | **Арга хэмжээ 4.2.** Тушаал шийдвэр цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллана. | Үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэсэн эсэх | | Үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж, эргэн тайлагнасан байна. | | Сайд, Төрийн нарийн бичгийн дарга, нэгжийн даргын өгсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэж, тайлагнаж ажилласан. | 2025.01-2025.06 сар | 100% |
| | **Арга хэмжээ 4.3.** Чиг үүргийн дагуу бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гарган, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ. | Холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн эсэх | | Хэрэгжилтээр | | Кибер аюулгүй байдлын тухай хууль болон бусад холбогдох хуулийн хэрэгжилт, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг сар бүр гаргаж, ТЗУГ-т хүргүүлэн ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд кибер аюулгүй байдлыг хангах, хүний хувийн мэдээллийг хамгаалах, тоон гарын үсгийн дэд бүтцийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой арга хэмжээнүүдийг төлөвлөж, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн. Мөн кибер аюулгүй байдлыг хангах гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэхтэй холбоотой арга хэмжээнүүдийг тухай бүр боловсруулж, СБТГ, ГХХАХ-т хүргүүлэн ажиллаж байна | 2025.01-2025.06 сар | 100% |
| | **Арга хэмжээ 4.4.** Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журам, стандартад нийцүүлэн баримт бичгийн төсөл | Хууль болон холбогдох журамд нийцүүлэн баримт | | Хэрэгжилтээр | | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох журмын дагуу албан бичгийн төсөл, захиргааны хэмжээний актын төслийг боловсруулж, албан бичгүүдийг шийдвэрлэж ажилласан. | 2025.01-2025.06 сар | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөх, архивын нэгж бүрдүүлнэ. | бичгийн төсөл төлөвлөж, архивын нэгж үүсгэсэн эсэх | | | | | | |
| | **Арга хэмжээ 4.5.** Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэн ажиллана. | Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэсэн тоо | - | Хэрэгжилтээр | | Тайлант хугацаанд өргөдөл гомдол ирээгүй. | 2025.01-2025.06 сар | Хэрэгжүүлэх хугацаа болоогүй. |
| | **Арга хэмжээ 4.6.** Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг мөрдөх хэрэгжилтийг ханган ажиллана. | Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлэх Ашиг сонирхлын мэдүүлгийн тоо | - | Ашиг сонирхлын мэдүүлгийн тоо - 1 | | Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг 2024 оны байдлаар гаргасан. Мөн хөрөнгө, орлогод өөрчлөлт орсонтой холбогдуулан хуулийн хугацаанд дээрх мэдүүлгийг цахим хэлбэрээр мэдүүлж, байгууллагын хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий албан хаагчид баталгааны маягтыг хүргүүлсэн. | 2025.01-2025.06 сар | 100% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги боловсруулах | Стратегийн төслийн тоо | - | 1 | Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх Үндэсний зөвлөлийн 2024 оны 02 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн | 2025.01-2025.06 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүрээнд мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратегийн төслийг боловсруулсан. Үндэсний зөвлөлийн 2025 оны 04 сарын 04-ний өдрийн хурлаар стратегийг хэлэлцэн баталсан. | | |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Үндэсний дата төв УТҮГ-ын дүрмийг шинэчлэн боловсруулах | Дүрмийн төсөл | - | 1 | Тагнуулын ерөнхий газрын 2025 оны ТЕГ03/139 тоот, Үндэсний дата төв УТҮГ-ын 2025 оны 01/122 тоот албан хүсэлтийн дагуу Үндэсний дата төв УТҮГ-ын дүрмийг шинэчлэн боловсруулсан. Дүрмийн төсөлд нийт 26 санал ирүүлснийг тусгаж, шинэчлэн найруулсан. ЦХИХХ-ны сайдын тушаалын төслийг боловсруулж, газрын дарга нараас санал авч тусгасан, Сайдад танилцуулж байна. | 2025.01-2025.06 сар | 90% |
| 3. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр арга хэмжээнүүд зохион байгуулах | Төлөвлөгөө гаргах<br><br>Арга хэмжээнүүд зохион байгуулах | - | 1 | Залуучуудын дундах цахим дээрэлхэлтийн талаар судалж, бууруулахад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах, олон нийтэд мэдлэг түгээх талаар зорилго, зорилт, рага хэмжээг тодорхойлж, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон ЦХИХХЯ хоорондын Төсөл эхлүүлэх төлөвлөгөөнд тусгуулан батлуулсан. Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах хүрээнд 2025 оны 04 сарын 02-ны өдөр "Залуучуудын цахим аюулгүй байдал" сэдэвт залуучуудын цахим аюулгүй байдлыг нэмэгдүүлэхэд олон талын оролцоог нэмэгдүүлэх хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, сурагчид нийт 50 гаруй хүн хамрагдсан. Мөн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Өсвөр үеийнхний цахим аюулгүй байдал” сэдэвт сургалтыг 2025 оны 06 сарын 13-ны өдөр | 2025.01-2025.06 сар | 100% |

| | | | | | зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. | | |
|---|---|---|---|---|---|---|---|

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Гүйцэтгэлийн түвшин | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1.<br>Худалдан авах ажиллагааны А3 сургалтад хамрагдах | Сургалтад хамрагдсан байна. | 0 | - | 1 | 2025 оны 2 сард худалдан авах ажиллагааны сургалт зохион байгуулагдах үед гадаад албан томилолттой байсан тул сургалтад хамрагдаагүй. | 2025.07-2025.12 сар | Тайлагнах хугацаа болоогүй |
| 2. | Арга хэмжээ 2.<br>Кибер аюулгүй байдлын чиглэлээр ажиллаж буй эмэгтэйчүүдийг чадавхжуулах сургалтад хамрагдах | Сургалтад бүрэн хамрагдсан байна. | 0 | 1 | - | Кибер дэх эмэгтэйчүүд хөтөлбөрийн хүрээнд 2025 оны 02 дугаар сарын 13-наас 21-ний өдрүүдэд зохион байгуулагдсан кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр ажиллаж буй эмэгтэйчүүдийг чадавхжуулах сургалт, хуралд хамрагдсан. сургалтын үеэр Монгол Улсын кибер аюулгүй байдлын сэдвээр танилцуулга хийсэн. | 2025.01-2025.06 сар | 100% |
| 3. | Арга хэмжээ 3.<br>Удирдлагын академиас зохион байгуулсан сургалтад хамрагдах | Сургалтад бүрэн хамрагдсан байна. | 0 | 1 | - | Монгол Улсын Ёс зүйн хороо болон Удирдлагын академиас хамтран зохион байгуулсан Ёс зүйн сургагч багш бэлтгэх сургалтад 2025 оны 5 сарын 21-23, 27-ны өдрүүдэд хамрагдаж, Z1452 дугаартай үнэмлэх авсан. | 2025.01-2025.06 сар | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Кибер аюулгүй байдлын бодлого зохицуулалтын газрын Ахлах шинжээч ........................... М.Оролзод ......... ......... .........